



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 59

Даланзадгад сум

“Чадварлаг багш” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 200, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Чадварлаг багш” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр баталж, арга хэмжээний зардлыг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д даалгасугай.
3. Боловсролын мэргэжлийн болон сургалтын байгууллага, төр, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, багшийн мэдлэг ур чадварыг сайжруулан, сургалтын чанарт ахиц гаргаж, хөтөлбөрийн тайланг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Р.Сэддорж/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАДРАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 01-ний  
өдрийн 59 дүгээр тогтоолын хавсралт

## **“ЧАДВАРЛАГ БАГШ” ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Хөтөлбөрийн нийтлэг үндэслэл**

Боловсролын салбарт бодитой хувь нэмэр оруулах, багш өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх, ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх нь боловсролын шинэчлэлийн нэн чухал асуудал билээ. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих бодлогыг холбогдох хууль, тогтоомж эрх зүйн баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж ирсэн.

Сургалтын үйл ажиллагааны чанар, суралцагчдын сурлагын амжилт, хүмүүжил төлөвшилд бодитой ахиц дэвшил гаргахад багшийн ажлын чанар гол үүрэг гүйцэтгэнэ. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг боловсролын олон талт үйл ажиллагаанд багш нарыг хамруулж, тэдний чадамжийг хөгжүүлэх, насан туршийн суралцах үйл хэмээн тодорхойлдог.

Хөдөө орон нутагт ажиллаж буй багш нарын мэргэжлийг тасралтгүй хөгжүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэргэжлээрээ бусдыгаа үлгэрлэн манлайлж буй багш нарын туршлагыг бусдад түгээн дэлгэрүүлэх чиглэлээр багш нарыг чадваржуулж сургалтын чанарыг сайжруулах шаардлага бий болсоор байна.

**Өмнөговь аймгийн хэмжээнд боловсролын салбарт ажиллаж буй багш нарын үндсэн тоон үзүүлэлтийг авч үзвэл:**

- ✓ Багш нарын боловсролын зэргийг нийт багшид харьцуулбал Доктор 0,1 хувь, магистр 41,5 хувь, бакалавр 84,5 хувь, Диплом 8,7 хувь, бүрэн дунд боловсролтой 0,8 хувь, бусад 1,8 хувьтай байна.
- ✓ Багшийн мэргэжлийн зэргийн үзүүлэлтээр Зөвлөх зэрэгтэй багш нийт багш нарын 0,76 хувь, Тэргүүлэх багш 7,8 хувь, Заах арга ч багш 19,1 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд Монгол Улсын гавьяат багш 10, Улсын оны тэргүүний багш 2 байна.
- ✓ Багш нарын насны ангиллалаар авч үзвэл 30 хүртэлх насны 29,0 хувь, 30-39 насны 41,7 хувь, 40-49 насны 17,5 хувь, 50-59 насны 9,2 хувь, 60 дээш 1,09 хувийг эзэлж байна.
- ✓ Багш нарын ажилласан жилийг тооцож үзвэл 5 дахь жилдээ ажиллаж буй 28,1 хувь, 6-10 дахь жилдээ 25,3 хувь, 11-15 жилдээ 16,5 хувь, 16-20 жилдээ 18,9 хувь, 21-25 хувь 5,5 хувь, 25 дээш 9,4 хувьтай байна.
- ✓ Мэргэжлийн багшийн хангалт 92,8 хувьтай бол мэргэжлийн бус болон багшийн дутагдалтай 7,2 хувь байна. Багш нарын шилжилт хөдөлгөөн сүүлийн 3 жилд шилжиж явсан 8,9 хувьтай, шилжиж ирсэн 12,4 хувьтай байгаа нь жил бүр сурагчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотой байна.
- ✓ Насан туршийн боловсролын салбарт ажиллаж байгаа нийт 20 багш ажиллаж байна. Үүнээс аймгийн Насан туршийн боловсролын төвд 4 багш, 14 суманд 16 багш ажилладаг.

**Насны ангиллалаар нь авч үзвэл:**

- ✓ 50 хүртэлх насны 45 хувь
- ✓ 50 дээш насны 45 хувь

Насан туршийн боловсролын мэргэжлийн багшийн хангалт 100 хувь дутагдалтай бусад насан туршийн боловсролын үндсэн 6 чиглэл болох гэр бүлийн

боловсрол, иргэний боловсрол, ёс зүй-төлөвшилтийн боловсрол, амьдрах ухааны боловсрол, гоо зүй-мэдрэмжийн боловсрол, шинжлэх ухааны боловсролын чиглэлээр багш нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулах шаардлагатай байгаа болно.

Эдгээр үндсэн үзүүлэлтээс харахад нийт багш нарын 70 хувь нь 40 доош насны залуучууд байгаа нь мэргэжлийн зэрэгтэй багшийн тоо бага байгааг тайлбарлаж болох ч багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж ажиллах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багш солилцоог хийх, багшийн ажлыг үнэлж дүгнэх, урамшуулж, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах хэрэгтэй байна

Нийгмийн хувьсал өөрчлөлт, суралцагчийн хөгжлийн хэрэгцээг хангасан, бүтээлч чадварлаг багшийг бэлтгэх, багшид мэргэжлийн стандартад суурилан уян хатан хэлбэрээр тасралтгүй хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэх, түүнд нээлттэй боловсрол, дижитал технологи ашиглах зэрэг хэрэгцээ шаардлага үүсч байна.

**“Чадварлаг багш” хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, үндэслэж боловсрууллаа.**

1. Боловсролын тухай хууль
2. Бага дунд боловсролын тухай хууль
3. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
4. Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
5. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)
6. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-Алсын хараа 2050
7. Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр
8. Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2021-2030)
9. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
10. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/07 дугаар тушаалаар батлагдсан “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр

Иймд Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрт багш өөрөө хөгжих “Чадварлаг багш” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлэхээр тусгасан.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго**

2.1. Мэргэжлийн стандартад суурилан, уян хатан хэлбэрээр багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэн, 21-р зууны боловсролын чиг хандлагад нийцсэн, суралцагчийн хөгжлийн хэрэгцээг хангасан бүтээлч, чадварлаг багшийг бэлтгэхэд оршино.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилт**

- 3.1. Багшийн мэргэжлийн мэдлэг, заах арга зүй, ур чадвар, хувь хүний хөгжил, хандлагын тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- 3.2. Багш өөрөө хөгжих орчин нөхцөл, боломжийг бүрдүүлэх
- 3.3. Багш нарын ур чадварыг үнэлж, урамшуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх

### **Дөрөв. Хамрах хүрээ**

- 4.1 Сургуулийн өмнөх боловсролын багш
- 4.2 Ерөнхий боловсролын сургуулийн багш
- 4.3 Насан туршийн боловсролын төв, нэгжийн багш
- 4.4 Өмнөговь аймгийн багш

#### 4.5 Политехник коллежийн багш

##### **Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

5.1. Багшийн мэдлэг, ур чадвар, харилцаа хандлагын тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.1.1. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах;

5.1.2. Багш нарын хэрэгцээ шаардлагад тулгуурласан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, гарсан үр дүнг тооцох;

5.1.3. Тэргүүлэх, зөвлөх зэрэгтэй багш нарын багийг байгуулж, багшийн сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

5.1.4. Залуу багш нарт “Дасан зохицох” хөтөлбөрийг хэрэгжүүлж, чадварлаг залуу багш нарыг бий болгох;

5.1.5. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, сургалтын байгууллага хоорондын түншийн холбоог бүрдүүлж, багшид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн, багш солилцоог хэрэгжүүлэх;

5.1.6. Сургалтын байгууллагын багш нарын мэргэжлийн бүлгээр хөгжүүлэх, сургагч болон чиглүүлэгч багшийг бэлтгэж, чадваржуулах ажлыг хийх;

5.1.7. "Сургалтын арга зүй-технологийн шинэчлэл" -ийг хөгжүүлэх, зохион байгуулах, арга зүйн санг бүрдүүлж, туршлагыг түгээн дэлгэрүүлэх;

5.1.8. Сургалтын байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын зөвлөн туслах багийн үйл ажиллагааг нэвтрүүлж, мэдлэг ур чадвартай багш нарыг урьж ажиллуулах;

5.2. Багш өөрөө хөгжих орчин нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.2.1. Багшийг хөгжүүлэх орчинг бий болгож, сургалтын хэрэглэгдэхүүн, техник тоног төхөөрөмжөөр хангаж, ашиглах чадварыг сайжруулах;

5.2.2. Сургалтын байгууллагуудын удирдлагын тогтолцоонд шинэчлэлт хийж, чадварлаг удирдах ажилтныг бүрдүүлэх;

5.2.3. Сургалтын хөтөлбөрийг аймгийн хэмжээнд судлагдахуун бүрээр нэгдсэн байдлаар боловсруулж, сургуулийн, сургалтын хөтөлбөрийн үнэлгээний тогтолцоог төгөлдөржүүлэх ажлын менежментийг сайжруулах;

5.2.4. Боловсролын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох;

5.2.5. Багш нарыг гадаадад суралцах боломжийг бүрдүүлж, олон улсын хөтөлбөрт хамруулах /"Хөгжлийн гүүр" хөтөлбөрөөр/;

5.2.6. Сайн дурын болон олон улсын байгууллагын гадаад багш нарыг урьж ажиллуулах;

5.3. Багш нарын ур чадварыг үнэлж урамшуулах, заах арга зүйн тэргүүн туршлагыг нийтийн хүртээл болгож нутагшуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.3.1 Багшийн мэдлэг ур чадварын гүйцэтгэлд суурилсан үнэлгээний аргачлалыг бий болгох;

5.3.2. Сургалтын чанар үр дүнгээр улс, аймгийн хэмжээнд массаар нь хөгжүүлсэн байдалд үнэлгээ хийж, урамшуулж дэмжих;

5.3.3. Багш, сурагчдын амжилтыг орон нутгаас дэмжиж, урамшууллын тогтолцоог шинэчлэн, хэрэгжүүлэх;

5.3.4. “Эрүүл багш” аяныг зохион байгуулж, багш нарыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүлжүүлэх;

5.3.5. Магистр, докторын сургалтад хамрагдах багшийг дэмжиж, судлаач багшийг нэмэгдүүлэх;

5.3.6. Багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, орон сууцжуулах ажлыг зохион байгуулах; /Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлын шийдвэрлэх тусламж, дэмжлэг үзүүлэх журмын дагуу/

5.3.7. Элсэлтийн ерөнхий шалгалтдаа өндөр оноо авч, багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд элсэн суралцаж буй оюутанд орон нутгаас урамшууллын тэтгэлгийг олгох;

### **Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

6.1. Хөтөлбөрийг 2021-2024 онд 1 үе шаттай хэрэгжүүлнэ.

### **Долоо. Хөтөлбөрийн хүрэх үр дүн**

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ.

7.1.1. Багш өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх орчин нөхцөл бүрдэнэ.

7.1.2. Багш нарын мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлагад гарсан өөрчлөлт нь сурагчдын сургалтын чанар, хүүхдийн төлөвшил хандлагад гарах өөрчлөлтөд нөлөөлнө.

7.1.3. Багш нарын ур чадварыг үнэлж, урамшуулан, нийгмийн баталгааг хангана.

7.1.4. Багш нарын заах арга зүйн тэргүүн туршлагыг нийтийн хүртээл болгоно.

7.1.5. Мэргэжлийн болон боловсролын, эрдмийн зэрэгтэй багшийн тоо нэмэгдэнэ.

### **Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт**

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2020 он/	Зорилтот түвшин
1	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан багш, нийт багшид эзлэх жин	Хувь	85	100
	Шилдэг арга зүйн санг бүрдүүлсэн багш	Тоо	87	150
	“Багш солилцоо”-нд хамрагдсан багш	Тоо	10	50
	Сургалтын чанар аймгийн дундаж, улсын дундаж үзүүлэлт	Хувь	23.6	30
	Сургуулиудад урилгаар ажиллаж зөвлөгөө өгсөн багш	Тоо	3	10

	Багшийн мэргэжлийн зэргийн нийт багшид эзлэх жин	Хувь	Зөвлөх багш 0,76 Тэргүүлэх багш 7,8 Заах аргач багш 19,1	Зөвлөх багш 1.2 Тэргүүлэх багш 15 Заах аргач багш 50
2	Дэмжлэг авсан багшийн хөгжлийн төв	Хувь	50	90
	Ментор /Сургагч/ багш	Тоо	6	30
	Чиглүүлэгч багш	Тоо	0	22
	Гадаад оронд мэргэжил дээшлүүлсэн багш	тоо	45	50
3	Багшийн хангалт	Хувь	7.2	2 хувиар ахиулах
	Улсын хэмжээнд шилдэг тэргүүний болж амжилт үзүүлсэн багшийн эзлэх жин	Хувь	0.2	1 хувиар ахиулах
	Магистр, докторын сургалтад хамрагдсан багшийн нийт багшид эзлэх жин	Хувь	33.5	5 хувиар ахиулах
	Орон сууцны дэмжлэгт хамрагдсан багш	Тоо	20	80
	Урамшуулал, дэмжлэгт хамрагдсан багш	Хувь	20	20 хувиар ахиулах

### Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

9.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- 9.1.1 Улсын болон орон нутгийн төсөв
- 9.1.2 Төсөл хөтөлбөр, хандив тусламж
- 9.1.3 Бусад эх үүсвэр

### Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

10.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг тухайн оны 12-р сард багтаан Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст хүргүүлнэ.

10.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх бөгөөд Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 1 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна. Мөн хагас жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн бодлого, хууль эрх зүйн хороонд танилцуулна.

10.3. Шаардлагатай тохиолдолд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 18 сараас доошгүй хугацааны дараа үр дүнд суурилсан явцын болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэж болно.